

МОНГОЛ ТЕЛЕВИЗИЙН 1977-1990 ОНЫ НИЙТЛЭЛИЙН БОДЛОГОД ХИЙСЭН ТОЙМ СУДАЛГАА

Ю.Эрдэнэтуяа*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), МУИС-ийн дэд профессор

Түлхүүр үг: Монгол телевиз, нэвтрүүлгийн бодлого, төлөвлөлт, өнгөт систем, сансрын холбоо, телевизийн хөтөлбөр, хүүхдийн нэвтрүүлэг, залуучуудын нэвтрүүлэг.

1977-1990 он бол телевиз үүсч байгуулагдсанаас хойшх арван жилд явуулсан нийтлэлийн бодлогын үргэлжлэл, уран бүтээлийн арвин өв уламжлалын залгамж, нэвтрүүлгийн агуулга, хэлбэрийн баяжилт, өөрчлөлт шинэчлэлтийн гарааны он жилүүд болон үлджээ. Үүний зэрэгцээ телевизийн нэвтрүүлгийг бүхэлд нь өнгөт системд бүрэн шилжүүлсэн, сансрын холбооны Экран ЧМ станцийг ашиглан орон даяар үндэсний нэвтрүүлэг цацдаг болсон, Москва, Сөүлийн Олимпийн их наадмыг шууд дамжуулсан, Интервидение байгууллагын гишүүн орнуудын хооронд болон CNN мэдээллийн телевизэд теле мэдээ дамжуулан солилцдог болсон зэрэг техник технологийн шинэ шинэ боломж нэвтрүүлж хүчин чадлаа нэмэгдүүлсэн жилүүд байжээ.

Телевизийн хөтөлбөрийг нэгэн өрх гэр бүлийн амьдралтай зүйрлүүлэн авч үзэх юм бол тухайн гэр бүлийн

гишүүдийн соёл, хүмүүжил, сонирхол, хөдөлмөр, боловсрол, эрүүл мэнд, амралт, чөлөөт цаг, идэвх оролцоо гээд бүхий л талыг хамарсан өргөн хүрээтэй цогц бодлого явуулахтай адил юм. Тиймээс телевизийн хөтөлбөрийн сүлжээг боловсруулах, нэвтрүүлгийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох, ямарваа нэг шинэ нэвтрүүлэг нээн явуулахдаа зорилго, чиглэл, агуулга, арга хэлбэр, хугацаа, давтамж, хэмжээ, ямар хугацаанд үргэлжлэх зэргийг урьдчилан төлөвлөж хэлэлцэн баталдаг байсан нь үзэгчдийн хэрэгцээ, шаардлагыг хангахад ихээхэн анхаарч иржээ. Түүнээс биш тохиолдлын чанартай ганц хоёр нэвтрүүлэг хийж үзээд орхих биш, тодорхой хугацаанд, системтэй бэлтгэн үзүүлэх, ингэснээр тодорхой үр дүнд хүргэхийг зорин ажилладаг байсан нь өнөө хэр сургамжтай, анхаарууштай зүйл юм. Телевизийн өрсөлдөөнт зах зээлд үзэгчдэд сайн чанарын бүтээгдэхүүн борлуулан, эрэлт хэрэгцээг нь байнга татаж байх үндэс нь сайн төлөвлөлт, оновчтой зохион байгуулалт болдог.

Тэгвэл 1977-1990 онд Монгол телевизийн нэвтрүүлгийн бодлого, чиглэл чухам юунд чиглэж, ямар үр нөлөөтэй

болж байсныг хөтөлбөрийн бүтцийн чиглэлээр баримт түшин судлан үзсэнээ толилуулъя.

Нэг. Телевизийн хамгийн идэвхтэй үзэгч нь хүүхэд

Аль ч телевизийн хамгийн идэвхтэй үзэгчид нь хүүхдүүд байдаг гэдгийг судлаачид нэгэнт тогтоосон байдаг. Монгол телевизийн хувьд ч хүүхдэд зориулсан нэвтрүүлэг хөтөлбөрт нь хүндтэй байр эзэлсээр ирсэн уламжлалтай. Эцэг, эхийнх нь нэгэн адил үе үеийн хүүхэд багачуулыг өсгөн хүмүүжүүлэхэд анхаарч тэдэнд бүх талын мэдлэг олгоход тус нэмэр болох зорилготой нэвтрүүлгийн бодлого, чиглэл баримтлан ажилладаг байсан нь тодорхой харагдлаа.

Тухайлбал, бага насны хүүхдүүдэд зориулсан "Авьяас", "Доремифа", "Оноо, хурд, хором", "Багачууд аа, сайн байцгаана уу?", "Хараацай" (1979 оноос), "Маамуу нааш ир" (1982 оноос), "Яагаад?" (1986 оноос), "Үлгэрийн орон" (1988 онд) нэвтрүүлэг бэлтгэн явуулж байв. Үзэгч хүүхдийн дотнын анд Боролдой хүүгийн үлгэрийн цагаар "Долоон хожгор, нэг можгор", хүүхдийн зохиолч Т.Жамъянсүрэнгийн "Могжоохон даагатай жогжоохон хүү", "Сэлмэн эвэрт ухна, шижээгүй зант хуц хоёрын үлгэр", Телекино үйлдвэрийн бүтээл "Эвтэй дөрвөн амьтан", "Жигүүр", "Дуулгавартай шоргоолж" хүүхэлдэйн кино болон гадаадын (телевиз хоорондын хамтын ажиллагааны гэрээний дагуу үнэ төлбөргүй нийлүүлж байсан Зөвлөлтийн болон бусад социалист орны) хүүхэлдэйн киног үзүүлдэг байсан байна. 1982 онд Францын "Ертөнцийн үүсэл" хэмээх гурван ангит хүүхэлдэйн киног ч бас үзүүлж

байжээ. Хүүхдийг багаас нь байгаль дэлхий, орчин тойрныхоо байгалийн сайхныг таньж мэдэх, хайрлан хамгаалах дадал, хүмүүжилтэй болгоход туслах зорилгоор "Миний сайхан эх орон", "Шим ертөнц", "Зугаатай аялал" нэвтрүүлэг явуулж "Бодисын зүйн ертөнцөд" (1980), "Байгаль эх" (1982) телеолимпиад зохион явуулж байжээ.

Сургуулийн бага, дунд ангийн сурагчдад зориулж "Хэзээд бэлхэн", "Улаан бүч" (1979 оноос), "Бүхий олон багачууд" (1980 оноос), "Таван дэлбээ" (1981), "Тахиа цаг" (1986 оноос) нэвтрүүлгийг сурагчдын сурлага хүмүүжил, ёс суртахуун, танин мэдэхүйн янз бүрийн булан хуудастай бэлтгэж байсан байна. Харин ахлах ангийн сурагчдад зориулж "Эрмэлзэл" (1979), "Мэргэжил бүхэн сайхан" (1980), "Мэргэжлийн тухай яриа" (1981), "Чин сэтгэлийн яриа" (1982), "Бид ХХI зууных" (1986), "Бид ямар болох вэ?" (1988) нэвтрүүлэг бэлтгэн явуулж янз бүрийн ажил мэргэжлийн онцлогийг таниулан мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдралын байр сууриа олох, үерхэл, нөхөрлөл, нинжин сэтгэлийн талаар илэн далангүй харилцан ярилцах арга хэлбэрээр бэлтгэж иржээ.

Хүүхдийн хийж бүтээх хүсэл эрмэлзлийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхэд чиглэгдсэн "Суръя, бүтээе" (1979 оноос), "Өсвөрийн техникч" (1981-82), "Бүгдээрээ хийж сурцгаая" (1986), "Биднийг дагаад хийцгээ" (1988) нэвтрүүлэг бэлтгэн радио холбоо, машин техникийн загвар зохион бүтээх, бэлэг дурсгал, гар урлалын бүтээл хийж сурахыг зааж зөвлөж байв.

Монголын пионерийн байгууллагатай хамтран хот, хөдөөгийн ерөнхий боловс-

ролын сургуулийн пионер сурагчдын дунд зохион явуулж тодорхой шалгуураар шатлан шалгаруулдаг, нэлээд өрсөлдөөнтэй нэвтрүүлэг бол "Бид Артект очно" орос хэл дээрх уралдаант нэвтрүүлэг байжээ. Түрүүлсэн баг нь багаараа ОХУ-ын Хар далайн эрэг дэх олон улсын пионерийн Артек зусланд явж амардаг уламжлалтай, олон ч жил бэлтгэж ирсэн, үзэгч хүүхдүүдийн танил болсон, орос хэл сурах хөдөлгөөн эрчимтэй өрнүүлэхэд ихээхэн тус нэмэр болж байжээ.

Ерөнхий боловсролын сургуулийн 8, 10 дугаар ангийн сурагчдын шалгалтанд зориулж монгол хэл, орос хэл, математик, хими, физик, түүх, уран зохиол, нийгэм судлалын хичээлээр "Багш зөвлөж байна" цуврал зөвлөлгөө явуулдаг байсан нь хүүхдэд зориулсан сургалт-танин мэдэхүйн нэвтрүүлгийн бодлогын нэг хэсэг болж байжээ. Түүнчлэн зарим хичээлээр тухайлбал, 1980-81 онд шугам зургийн, 1982 онд математикийн теле олимпиад зохион явуулж, хэд хэдэн даваагаар шалгаруулан дүгнэдэг байсан нь сурагчдын дунд тухайн хичээлийг баяжуулан судлах идэвхийг өрнүүлэхэд ач тустай болж байв.

НҮБ-аас 1979 оныг хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын жил болгон тэмдэглэн өнгөрүүлэх тухай шийдвэрлэсний дагуу Монгол улсад энэ оныг "бүхнийг хүүхдийн төлөө зориулах" уриан дор тэмдэглэн өнгөрүүлжээ. Үүнтэй холбогдуулан Монгол телевизээс "Наран үүрд мандаг", "Бүхнийг хүүхдийн төлөө" цуврал нэвтрүүлэг бэлтгэн явуулсаны дээр хүүхдийн эрхийн олон улсын өдөр 6-р сарын 1, хичээлийн жилийн нээлт 9-р сарын 1-ний өдрийн

хөтөлбөрийг бүхэлд нь хүүхдүүдэд зориулсан телевизийн өдөрлөгийг зохион явуулж байсан байна. Хожим 1983 онд тэмдэглэсэн сурагчийн жилд энэхүү уламжлалаа давтан хэрэгжүүлсэн байна.

Монгол телевиз үзэгч хүүхдүүдийнхээ эрх ашиг, хүсэл сонирхлыг өөрийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх талаар байнга анхаарч ажилладаг байсны нэг илрэл бол сурагчдын өвөл, хаврын амралтын үеэр хүүхдүүдийн үзэх дуртай телевизийн олон ангит уран сайхны киног өглөө, өдрийн цагаар, нэмэлт өдрөөр үзүүлж байжээ. Энэ нь тэр үедээ л хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх үр нөлөөтэй арга болдог байсныг эцэг эх, сурган хүмүүжүүлэгчдээс телевизэд хандаж ирүүлдэг байсан олон зуун захидал, талархал гэрчилнэ. "Нохойтой дөрвөн танкчин", "Аминаас чухал үйлс" Польшийн телевизийн олон ангит кино, "Километр бүрт" Болгарын телевизийн олон ангит кино, "Оддын охин" Чехословакийн телевизийн олон ангит кино, "Баригдашгүй өшөө авагчид", "Электрон жаалын адал явдал" Зөвлөлтийн телевизийн олон ангит кино, "Фердинанд өвөө" БНАГУ-ын телевизийн олон ангит кино зэргийг хэчнээн олон дахин гаргасан ч үе үеийн хүүхдүүд уйддаггүй үздэг байжээ.

Монгол телевизийн техник технологийн баазын хүчин чадал, хүрэлцээ хангамж, уран бүтээлчдийн мэргэжлийн чадавх нь тухайн үед телевизийн олон ангит цуврал кино хийх хэмжээнд хараахан бэлтгэгдээгүй байсан хэдий ч өөрсдийн нөөц боломжид тулгуурлан уран сайхны тавилттай томоохон хэмжээний бүтээл болох теле жүжиг,

хүүхэлдэйн жүжиг, зохиомжийг сар, улирал тутам бэлтгэн үзүүлж байсан байна. Тухайн үед телевизэд Монголын хүүхдийн нэрт зохиолчид М.Чимид, Г.Ловор, Д.Батбаяр, Т.Жамъянсүрэн нар ажиллаж байжээ. "Бүжингийн театр"-ын цагаар 1977 онд Д.Мягмарын "Зарлал", 1979 онд "Борхүү", "Миний чин зоригт бяцхан найз", 1981 онд Ч.Лодойдамбын "Болд, Эрдэнэ хоёр" зохиомж, Б.Нямаагийн "Алим", Е.Л.Шварцын "Алдагдсан цаг", 1982 онд С.Надмидын "Найзууд" телезохиомж, А.Очирбатын "Баавгай дуулах уу?", С.Маршакийн "Муурын байшин", "Үзэсгэлэнт Пульхерий", "Чебурашка", Х.Зандраабайдийн "Гологдсон гурав" хүүхэлдэйн жүжиг, 1983 онд Д.Гармаагийн "Урнаагийн аав хэн бэ?", 1984 онд Ц.Нацагдоржийн "Арслан зүрхтэй туулай" жүжиг, А.Чойсонгийн "Хүн чулуу", Вьетнамын "Там, Кам хоёр" хүүхэлдэйн жүжиг, 1985 онд Ц.Ням-Осорын "Нөхрийн тус" хүүхэлдэйн жүжиг, Б.Зубровын "Даалгавар", Д.Дождооржийн "Цаг", Л.Лхасүрэнгийн "Хэн бэ?", Г.Батаагийн "Ишиг гэдэг хөөрхөн нэр", Ц.Дашдондогийн "Гурван найз, гурван дайсан", С.Михалковын "Хулчаахай", 1986 онд И.Кинчанова, В.Лившиц нарын "Олддоггүй Арман" хүүхэлдэйн жүжиг, Л.Петровагийн "Анчин мэргэн", С.Михалковын "Бардам туулай", "Дээвэр дээр суудаг Карлсон, жаал хүү хоёр", 1987 онд "Тэрх нуурын дэгдээхэй" зэрэг

жүжгийг шинээр болон давтан үзүүлж байжээ.

Түүнчлэн 1982-83 онд "Алиа Тогмид", "Зад угаагч", Хонх" гэсэн хүүхдэд зориулсан хошин шог сэтгүүл бэлтгэн үзүүлж байв.

Хүүхдийн нэвтрүүлгийн бодлогод багш, эцэг, эхчүүдэд зориулсан нэвтрүүлэг бэлтгэх асуудлыг ч тусгаж иржээ. Хүүхдийн хүмүүжил, нас, сэтгэхүйн онцлог, гэр бүлийн хүмүүжил, зан суртахууны төлөвшил зэрэг олон асуудлаар "Хүүхдийн төлөө", "Бүхнийг хүүхдийн төлөө", "Хүмүүжих орчин" зэрэг нэвтрүүлэг бэлтгэн үзүүлж байв. 1980-аад оны дундуур ЗХУ-д сургалтанд шинэ арга барил нэвтрүүлэн ажиллаж байгаа зарим багш нарын арга

«

Хүүхдийн нэвтрүүлгийн бодлогод багш, эцэг, эхчүүдэд зориулсан нэвтрүүлэг бэлтгэх асуудлыг ч тусгаж иржээ.

Хүүхдийн хүмүүжил, нас, сэтгэхүйн онцлог, гэр бүлийн хүмүүжил, зан суртахууны төлөвшил зэрэг олон асуудлаар нэвтрүүлэг бэлтгэн үзүүлж байв.

»

туршлагыг өргөн сурталчилж эхэлсэн. Ийм арга туршлагыг Монголын багш нарын ажилд нэвтрүүлэх зорилгоор Зөвлөлтийн телевизийн нэвтрүүлгийг орчуулан гаргадаг байсан байна. Тухайлбал, 1986 онд математикийн багш В.Ф.Шаталовтой хийсэн уулзалт, 1987 онд ЗСБНХУ-ын сурган хүмүүжүүлэх ухааны академийн сурвалжлагч гишүүн, сэтгэл зүйн ухааны доктор Ш.Амонашвилитэй хийсэн уулзалт, гавьяат багш И.П.Волковтой хийсэн уулзалтыг нэвтрүүлж байжээ. Дараа нь Боловсролын яам, аймаг, нийслэлийн боловсролын газруудтай хамтран "Бүтээлч багш" гэсэн цуврал нэвтрүүлэг санаачлан хийж,

гавьяат багш А.Оюунханд, Д.Дамдинжав, Увс аймгийн арван жилийн хоёрдугаар сургуулийн багш Г.Гомбожав, Завхан аймгийн Тосонцэнгэл хотын 10 жилийн дунд сургуулийн захирал Ж.Нацаг нартай багш нарын уулзалт зохион байгуулан нэвтрүүлж тэдний сургалтын арга туршлагыг дэлгэрүүлж байсныг тухайн үеийн хөтөлбөрөөс түүвэрлэн нэгтгэв.

Хоёр. Телевизийн хөтөлбөрийн чимэг нь залуучуудад зориулсан нэвтрүүлэг

Телевизийн хөтөлбөрийн сор болсон сонирхолтой нэвтрүүлгүүдийг ихэвчлэн залуучуудын редакцийн гар, сэтгэл нийлсэн, бүтээлч, авьяаслаг, хурц дайчин сэтгүүлч, найруулагчид бэлтгэж иржээ.

Залуучуудын нэвтрүүлэг бүх талын өв тэгш хүмүүжилтэй болгоход чиглэгддэг байснаас ахмад үеийнхний ажил амьдралын арвин баялаг туршлагаас суралцах, бие бялдар, оюун санаа, танин мэдэхүй, мэргэжил, мэдлэг, авьяас чадвараа сорьсон, залуу насны цог хийморь, тэмүүлэл, эрч хүч, гал дөлийг бадраасан уралдаант, цэнгээнт, аз сорьсон, зугаатай, наргиатай нэвтрүүлгүүд хийдэг байсан нь үзэгчдийн сонирхлыг зүй ёсоор татдаг байжээ.

Залуучуудад зориулсан "Одонт тугийн эзэд", "Тэмүүлэл" телесэтгүүл бэлтгэн явуулж, эвлэлийн байгууллага, гишүүдийн ажил үйлс, алдар гавьяа, үүсгэл санаачилга, үйл ажиллагааг өгүүлнэ. Энэ нэвтрүүлгээр тухайн жил залуучуудын амьдралд тохиолдох томоохон ой, тэмдэглэлт үйл явдалд зориулсан цуврал дугаарыг бэлтгэдэг

байв. Тэдгээрийн нэг нь дэлхийн залуучууд оюутны ээлжит их наадамд зориулсан цуврал нэвтрүүлэг. 1948 онд Прага хотноо ДЗО-ны анхдугаар их наадам болсноос хойшх удаа дараагийн их наадамд Монголын залуучууд хэрхэн оролцож ирсэн түүхэн уламжлал, дурсамжийг ч ээлж дараалан үзүүлж байж. 1972 онд Берлинд зохиогдсон ДЗО-ны их наадмаас эхлээд Монголын телевизийн сурвалжлах хэсгийнхэн их наадмын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцон явж сурвалжилдаг байсан байна.

Сэтгүүлч Б.Дорж, оператор Ч.Лхагважав нар энэ их наадмын ажиллагааг сурвалжлан телевизийн баримтат кино хийсэн байна. Их наадмын ажиллагааг ганцхан кино болон дүрс бичлэгийн камераар авдаг, ирсэн хойноо тухайн үйл явдлын талаар маш дэлгэрэнгүй үзүүлж харуулсан олон цаг, олон удаагийн нэвтрүүлэг бэлтгэн өөрийн үзэгчиддээ сонирхуулдаг байжээ. Ардчилсан Герман-Монголын залуучуудын найрамдлын чуулга уулзалтын ажиллагааг Монгол телевизийн оператор Т.Машбат дүрс бичлэгийн зөөврийн сурвалжлагын төхөөрөмжөөр тасралтгүй авч байсныг мэргэжил нэгт герман нөхөд нь хараад түүний ур чадварыг гайхан биширч байсан гэдэг. 1989 онд ДЗО-ны XIII их наадмын нээлтийн ажиллагааг Пхеньян хотоос шууд дамжуулан үзүүлж байжээ. Зөвхөн ДЗО-ны их наадам төдийгүй, Монгол-Зөвлөлтийн, Монгол-Чехословакийн зэрэг хоёр орны залуучуудын найрамдлын чуулга уулзалтууд харилцан зохиодог байсныг өргөн хүрээнд үзүүлдэг байсныг баримт түшин дурдаж болно. Ер нь иймэрхүү их

наадам, уулзалт нь найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх, бие биенээсээ харилцан суралцах, өөр өөрсдийн ололт амжилтаа илтгэн харуулах нийгэм, соёлын томоохон арга хэмжээ болдог байсан учраас залуучуудын болон соёл урлагийн, нийт байгууллагын хамт олон ихээхэн анхаарч бэлтгэдэг байсан нь тухайн үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогын төвд ийнхүү анхаарч тусгагддаг байжээ.

Залуучуудад зориулсан нэвтрүүлгийн бодлогын нэг чиглэл нь залуучуудыг ахмад үеийн баатарлаг, хөдөлмөрч, дайчин уламжлалаар хүмүүжүүлэхэд чиглэгдсэн "Алдарт хүмүүс" (хожим нь "Суут хүмүүсийн амьдралаас" болсон), "Гавьяа", "Залуусын танхим", "Нэг үеийнхэн" зэрэг нэвтрүүлэг бэлтгэж, цэрэг, эх оронч хүмүүжлийн тухай "Ардын цэрэг" (1978 оноос "Эх орны төлөө" нэртэй болсон) нэвтрүүлгийг бэлтгэн явуулж байжээ.

"Гавьяа" нэвтрүүлгээр ариун цагаан хөдөлмөрийнхөө үр шимээр алдар гавьяаны эзэн болсон хүмүүсийн тухай цуврал хөрөг найруулал бэлтгэж байсан байна. Энэ нэвтрүүлгийг авьяаслаг сэтгүүлч Батын Дорж хариуцан бэлтгэж 1978 оноос эхлэн 60 цуврал найруулал бэлтгэн 1981 онд Ардын хувьсгалын 60 жилийн ойгоор энэ нэвтрүүлгийн баатрууд оролцсон "Одонгоо зүүцгээ" гэсэн төгсгөлийн дугаарыг бэлтгэн үзүүлж байжээ. "Гавьяа" нэвтрүүлгийн баатруудыг жагсаавал: БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, Т.Жамц, Даваасамбуу, Н.Цэрэнпил, Н.Нацагдорж, Г.Данзандаржаа, Цэрэндорж, Б.Лувсан, Султаан, Д.Базаргүр, Пашка, төрийн шагналт, хөдөлмөрийн баатар, шинийг

санаачлагч Д.Пүрэвдаш, АИХ-ын депутат, хөдөлмөрийн баатар, зөвлөх малчин Санжжав, АИХ-ын депутат, хөдөлмөрийн баатар, ногоочин Бадамсүрэн, АИХ-ын депутат, Ерөөгийн САА-н комбайнч М.Алтангэрэл, Хөдөлмөрийн баатар, АИХ-ын депутат, адуучин С.Шарбанди, Баян-Өлгий аймгийн барилгын бригадын дарга, хөдөлмөрийн баатар Зяйтин, Хөдөлмөрийн баатар, төрийн шагналт, хоньчин С.Цогтгэрэл, Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн их эмч, хөдөлмөрийн баатар Дэлэг, Ардын жүжигчин Дамдинсүрэн, Гавьяат жүжигчин Жавзмаа, Ю.Оюун, Өмнөговь аймгийн Булган сумын Туяа нэгдлийн хоньчин, хөдөлмөрийн баатар Д.Аюурзана, Хөдөлмөрийн баатар, оёдолчин Б.Цэнд-Аюуш, гавьяат нэгдэлчин Т.Дагдан зэрэг алдартнуудыг нэрлэж болно.

"Гавьяа" нэвтрүүлгийн редактор, сэтгүүлч Б.Доржийн дүрсээр сэтгэх, дүрс, бичвэр хоёрын уялдааг зохицуулах нарийн мэдрэмж, авьяас өнөө хэр телевизийн сэтгүүлчдийн эзэмшвэл зохих ур чадварын нэг юм.

Залуучуудыг ахмад үеийн баатарлаг, хөдөлмөрч, дайчин уламжлалаар хүмүүжүүлэхэд чиглэгдсэн өөр нэг нэвтрүүлэг нь "Залуусын танхим" байжээ. Энэ нэвтрүүлгээр ардын жүжигчин С.Гэндэн, Данзан, гавьяат жүжигчин Ж.Содном, гавьяат хуульч, дэслэгч генерал Цэдэн-Иш, ардын жүжигчин, бүжиг дэглэгч Сэвжид, төрийн шагналт зохиолч Э.Оюун, С.Удвал нарын зэрэг олон нэрт хүмүүс залууст өөрсдийн амьдрал, тэмцлийн замнал, сургамжтай сайхан дурдатгалаасаа хуучилсан байна.

МХЗЭ-ийн 60 жилийн ойд зориулж 1980 оноос "Нэг үеийнхэн" нэвтрүүлэг санаачлан хийж МХЗЭ-ийн 104-р үүрийн гишүүд, 1939 оны Халх голын тулалдаанд оролцож явсан эвлэлийн гишүүн ахмад дайчид, Аж үйлдвэрийн комбинатын ууган ажилчид, Булган аймгийн Хушуу танхимын сургуулийнхан, анхдугаар таван жилийн ударникууд, МУИС-ийн анхны төгсөгчид, УБТЗ-ын анхныхан, атар эзэмших анхны аяныхан зэрэг үе үеийн залуучуудын дүр төрхийг харуулахыг зорьж байжээ.

Залуучуудад зориулсан нэвтрүүлгийг хөгжилтэй, хэмнэлтэй, өрсөлдөөнтэй, зугаатай, наргиатай хийх, залуу насны эрч хүч, авьяас, цог золбоог харуулсан цэнгээнт төрөл зүйлээр бэлтгэхийг ихэд чухалчилдаг байжээ. Ер нь тэр үед телевизийн цэнгээнт нэвтрүүлгийн эхлэлийг тавьсан нэвтрүүлгүүдийг хийж байсан гэж үзэж болно. Тухайлбал, 1970-аад оноос хийж ирсэн "Авхаалж сэргэлэнчүүдийн клуб" уралдаант нэвтрүүлэг, 1980 оноос танин мэдэхүйн асуулт хариултын "1:6=?" нэвтрүүлгийг Зөвлөлтийн телевизийн "Что, где, когда?" нэвтрүүлгийн жишгээр бэлтгэн гаргаж байсан байна.

1977 оноос "18-ын клуб", 1978 оноос "Залуучууд дэлгэцнээ", 1982 оноос "Хөвгүүд", "Бүсгүйчүүл", 1987 оноос "Манайд ирээрэй", 1988 оноос "Дөрвөн бэрх" зэрэг уралдаант, хөгжөөнт нэвтрүүлэг бэлтгэн үзүүлж байжээ.

Залуучууд дэлгэцнээ нэвтрүүлгээр төмөр замчин, цэцэрлэгийн багш, геологич, оюутан, тээвэрчид, барилгачин, эм найруулагчид, ноосон нэхмэлч, зураач, барималч, нисэгч, техникч, үйлчлэгчид, гал сөнөөгчид, тогооч, үйлчлэгчид,

худалдааны ажилтан, уурхайчин, холбоочин залуус оролцон ажил мэргэжлээрээ уралдан бахархуулдаг байв.

Монголын телевизийн ууган найруулагчдын нэг Сандагдоржийн Бадрах Монголын цэнгээнт нэвтрүүлгийн нэрт мастер, авьяас билэг танхай найруулагч байсан тухай телевизийн уран бүтээлчид ам булаалдан хэлдэг. Найруулагч С.Бадрахын цэнгээнт нэвтрүүлгийг зохион байгуулах, өвөрмөц, сонирхолтой арга хэлбэр, зохиомж олох, нэвтрүүлгийн зураг дүрслэлийг оновчтой ашиглах, эвлүүлэх ур чадварыг сайн эзэмшсэн найруулагч байжээ.

Нэгэн үе Зөвлөлтийн телевизийн нэвтрүүлгийг хуулбарлахаа болих талаар ярилцаж өөрийн гэсэн өнгө төрхтэй "монголжуу" нэвтрүүлэг санаачлан хийхийг зорих болсон тэр үед С.Бадрах нарын санаачлан зохиосон "Дөрвөн бэрх" нэвтрүүлэг ардын зан заншил, уламжлалыг залуу үеийнхэнд таниулах зорилгоор шагайн бэрх буулгах замаар шодож асуулт тавин багаараа хариулах хэлбэрээр өрсөлддөг монгол ахуйн шинэ нэвтрүүлэг гаргаж ирсэн байна. Түүнчлэн 1986 онд "Адуучид" нэвтрүүлэг бэлтгэн Дорноговь, Өвөрхангай, Төв, Хэнтий, Увс, Төв, Булган аймгийн малчин залуусыг оролцуулж байсан нь ихэд сонирхолтой сайхан нэвтрүүлэг болж өнөө хэр телевизийн Алтан фондод хадгалагдан үлдсэн байна. Энэ нэвтрүүлгийг үргэлжлүүлэн 1987 онд "Тэмээчид", "Ойчид", "Замчид" зэрэг ажил мэргэжлийн залуус оролцож авхаалж самбаа, мэргэжлийн ур чадвараа сорьдог сонирхолтой нэвтрүүлэг явуулдаг байсан байна.

Залуучуудын нэвтрүүлэг ахмадын алтан сургаалийг сонсохын зэрэгцээ залуус өөрсдөө ажил хөдөлмөр, амьдралын байр суурь, баяр жаргал, зовлон бэрхшээлээ чин сэтгэлээсээ ярилцаж нэг нэгнээсээ суралцах, нэг нэгэндээ дэм болох зорилготой нэвтрүүлгүүдийг ч хийдэг байсан. "Залуусын танхим", 1986 оноос "Залуустай ярилцах цаг", 1987 оноос "Редакцийн томилолт", 1989 оноос бэлтгэж байсан "Цаг үе-залуучууд" нэвтрүүлэг ийм нэвтрүүлгийн тоонд орно.

"Залуустай ярилцах цаг" нэвтрүүлгээр "Архи амьдралын дайсан", "Анхны хайр", "Залуу насаа хайрлаж яваарай", "Аав аа та хаа явна?", "Цэргийн амьдрал нууц гэж үү?", "Хүн хүнээ хайрлаж явъя" зэрэг асуудал хөндсөн чин сэтгэлийн ярилцлага, эргэцүүлэл хийж байлаа.

1987 оноос Дундговь, Хэнтий, Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ зэрэг олон аймгийн сум нэгдэл, сангийн аж ахуйгаас сэтгүүлч Ш.Гүрбазарын санаачлан хийж байсан "Редакцийн томилолт" нэвтрүүлэг залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаар асуудал дэвшүүлэн хөндөж байсан үр өгөөжтэй нэвтрүүлэг болж байв. "Тэсийн залуус хүлээсээр байх уу?" нэвтрүүлэг Баян-Өлгий аймгийн хөдөлмөр эрхлээгүй залуусын санал бодол, ажилчин, малчин, саальчин эмэгтэйчүүдийн нийгмийн асуудлыг дэвшүүлэн тавьж байлаа. Сэтгүүлч Ш.Гүрбазар Монголын Телевизийн сэтгүүл зүйн урлагт иргэний эргэцүүлэл маягийн нийтлэл нэвтрүүлгийг хөгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Түүний "иргэнлэг" чанарыг агуулсан нэвтрүүлгүүдийн анхны эх суурийг тавьсан бүтээл бол "Говийн ганц айл" хэмээх асуудал дэвшүүлсэн ярилцлагын нэвтрүүлэг юм.

"Говийн ганц айл" нэвтрүүлэг нь говийн өрх толгойлсон эмэгтэйчүүдийн нийгмийн хурц асуудлыг хөндөж тэр үедээ нилээн шуугиан тарьсан нэвтрүүлэг болж байлаа. "Говийн ганц айл" нэвтрүүлэг нь нийт зургаан цуврал дугаар гарсан бөгөөд эхний хоёр дугаарыг 1989 оны 6-р сард Өмнөговь аймгийн Баян-Овоо, Гурвантэс, Ноён сумын нутгаас бэлтгэжээ.

Ш Гүрбазарын "Говийн ганц айл" нэвтрүүлэг болоод ■ сэтгүүлчийнх нь ур чадварыг сэтгүүл зүйн доктор профессор Л.Норовсүрэн дүгнэхдээ: "Ярилцах хүнээ сайн судалж, түүнд чин сэтгэлээсээ хандах, ухаалаг асуулт тавьж, баяр гунигийг хуваалцаж чаддаг шинжээр ярилцлагынх нь ур дүй илэрч байдаг бол, уран сайхны нэвтрүүлгээ хүний сэтгэлийг хөдөлгөн уянга, туульсийн аргыг өргөн хэрэглэж, үгийг онож хэрэглэх, дуу хоолойн өнгө аяс, өндөр намыг тааруулахад ихээхэн анхаардаг нь Ш.Гүрбазарын ур чадварын үндэс ажээ. Чухам энэ л чанарыг шингээж чадсанаараа "Говийн ганц айл", "Говийн хүүхнүүд" нэвтрүүлгүүд нь түүний нэрийн хуудас болж үлдсэн билээ"¹ гэсэн байдаг.

Телевизийн шуурхай байдал, хаа сайгүй нэвтэрч чаддаг түгээмэл шинж чанар, нэг дор асар олон хүний оюун санааг эзэмдэж чадах нөлөөлөлт онцлогтой салшгүй холбоотой. Тиймээс шууд нэвтрүүлэг нь тухайн нэвтрүүлэг бэлтгэгч уран бүтээлч, инженер-техникийн ажилтнуудын ур чадварыг дээд зэргээр дайчлан зохион байгуулдаг, тэр хэмжээгээрээ хариуцлагыг өндөржүүлдэг бүтээлч үйл ажиллагааны хэмжүүр болдог. Улс хувьсгалын баяр наадмын

ажиллагааг залуучуудын редакцийн хамт олон нэвтрүүлэн үзүүлдэг байв.

Биеийн тамир, спортыг залуу насны эрч хүчний гайхамшиг хэмээн үздэг тул спортын нэвтрүүлгийг залуучуудын нэвтрүүлгийн бодлоготой уялдуулан авч үздэг байжээ. 1977-1987 онд спортын нэвтрүүлгийн хэмжээ өмнөх үеийнхээс харьцангуй нэмэгдсэн байна. Энэ нь манай оронд зохиогдох улс, олон улсын уралдаан, тэмцээн олон зохиогдох болсонтой холбоотой. Нөгөө талаар биеийн тамир, спортыг бүх нийтийн үйлс болгон өрнүүлэх хөдөлгөөн эрчимжсэнтэй ч холбоотой байв.

1977 оноос спортын төрөл бүрийн хичээлийг телевизээр зааж байсан байна. Жишээлбэл, даамны хичээл, шатрын бодлого, ХБХБ тэмдгийн норм биелүүлэх заавар, тэшүүр, хоккейн талбайн дүрэм, хөнгөн атлетик, байт харваа зэрэг спортын олон төрлийн талаар ярьж таниулж байжээ.

Спортын шууд сурвалжлагын хэмжээ ч нэмэгдсэн. Олон улсын бөхийн чөлөөт барилдааны жил бүрийн “Интернационал” тэмцээн, ах дүү армиудын бөхийн чөлөөт барилдааны “Нөхөрлөл” тэмцээн, бөхийн жүдо барилааны олон улсын тэмцээн зэрэг уламжлалт тэмцээнүүдийг үзэгчиддээ шууд дамжуулан үзүүлдэг байв. Бөхийн чөлөөт барилдааны дэлхийн залуучуудын 1979 оны аврага шалгаруулах тэмцээнийг 1983 онд МТВ, СТО-ны нэрэмжит начингуудын барилдаан, 1986 оноос МТВ-ийн нэрэмжит самбо барилдааны аварга шалгаруулах тэмцээн, мөн Нэгдэлчдийн баяраар НХДЗ, МРТУХ-ны нэрэмжит Үндэсний бөхийн барилдааныг жил бүр уламжлал болгон явуулж ирсэн.

Дэлхийн өвөл, зуны Олимпийн наадам угтсан ажлыг тогтмол сурталчлан, Олимпийн хөдөлгөөнийг эрчимжүүлэхэд анхаардаг байв. Монголын телевизийн сурвалжлах хэсэг анх 1980 оны Москвагийн Олимпийн наадмын ажиллагааг шууд дамжуулан үзүүлсэн түүхтэй юм. Энэ Олимпид найруулагч С.Бадрах, инженер С.Цэдэвсүрэн, тайлбарлагч Намшир нарын бүрэлдэхүүнтэй баг ажиллаж Олимпийн хэвлэлийн төвд албан ёсны аккредитаци хийлгэн сансрын холбооны сувгаар тусгай цаг захиалан нээлт, хаалтын ажиллагаа болон манай тамирчид оролцсон чөлөөт бөх, буудлагын тэмцээнийг шууд дамжуулан үзүүлж байсан. Чадварлаг цөөн хүний хүчээр олон цагийн шууд нэвтрүүлгийг амжилттай хийж гүйцэтгэж байжээ. Дараа дараагийн Сөүл, Бээжингийн Олимпийн наадамд ч Монгол телевизийн сурвалжлах баг ажиллаж байжээ.

1980 оны телевизийн хөтөлбөрийг судлан үзвээс 7-р сарын 19-нд Дэлхийн зуны XXII Олимпийн нээлтийн ажиллагаанас хийсэн шууд сурвалжлага, 7-р сарын 21, 24, 26, 27, 29, 31, 8-р сарын 2, 3-нд Олимпийн өдрийн тэмдэглэл нэртэй нэвтрүүлэг бэлтгэн үзүүлж байсан байна. Мөн Олимпийн тоглолтыг Орбитын нэвтрүүлгээр орон даяар үзүүлсэн нь үзэгчдийн сэтгэгдэлд ихээхэн нийцсэн арга хэмжээ болж байжээ.

Үргэлжлэл бий.

Ишлэл

¹ Норовсүрэн Л. 2001. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Дэд боть. УБ., 115 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Наранжаргал Х. 2006. Телевизийн сэтгүүл зүй: үндсэн ойлголт, зөвлөмж. УБ.
2. Норовсүрэн Л. 2001. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Дэд боть. УБ.
3. Галушко Р. И. 1996. Теле-радиожурналистика: вчера, сегодня, завтра. М.
4. Кузнецов Г. В., Цвик В. Л., Юровский А. Я. 2002. Телевизионная журналистика. М.
5. Сапунов Б. М. 1988. Телевидение и культура. М.
6. Цвик В. Л. 2004. Телевизионная журналистика: история, теория, практика. М.
7. Lunt P. 1993. Talk on Television. St.
8. Fiske J. 1987. Television Culture. London.

Резюме

Автор в настоящей статье затронула основные вехи развития Национального телевидения Монголии. В частности, автором был выбран период с 1977 года по 1990-й год, когда произошло бурное развитие телевидения в материально-техническом плане. За прошедшие с момента основания 10 лет монгольское телевидение значительно окрепло в техническом отношении, наметилась устойчивая тенденция программной политики, обогатились содержание и форма подачи программ. Кроме того, телевизионная программа полностью стала цветной, а при помощи станции космической связи Экран ЧМ транслировала передачу на всю страну. Особым явлением для монгольской аудитории стала прямая трансляция Московской и Сеульской Олимпиад.